




Цэргийн урлаг

“ХӨХ СУДАР” БА ЭРТНИЙ МОНГОЛ ЦЭРГИЙН УРЛАГ.

“Хөх судар” романыг Чингисийн 27 дахь үеийн ач Л. Ванчинбал (1794-1847) 1839 онд эхэлж 8 бүлэг бичиж үлдээснийг хүү Инжинаш (1837-1892) нь гүйцээн бичжээ. Романыг Их монгол улсыг байгуулахаас Юань гүрнийг шувтрах хүртэл 200 шахам жилийн түүхэн хэрэг явдлыг үзүүлсэн 120 бөлөг 12 товчит толттойгоор бичихийг зорьж байсан гэх боловч эдүгээ бидэнд олдсон нь 69 бөлөг, 8 товчит толт юм. Эхний 60 бөлөгт Чингис, үлдсэн 9 бүлэгт Өгэдэй хааны үеийн хэрэг явдлыг өгүүлжээ.

Зохиогч “Товчит тогтлоо” эл бүтээлийг туурвих болсон зорилго, ямар зарчим дарааллаар бичсэн, сурвалж бичгүүдэд хэрхэн хандаж алдаа мэдгийг зассан, зохиолыг хэрхэн уншвал зохихыг заахын хамтаар Манжийн колончлолын хорт бодлогыг илчлэн шүүмжилсэн бол романыхаа хэсэг тархай бутархай аймгуудыг нэтгтэн Их Монголд улсыг байгуулсан XIII зууны түүхэн үйл явдлуудын мөн чанар, болсон цаг хугацаа, түүнд оролцсон түүхт хүмүүс, цэргийн жанжин, тухайн нийгмийн дүр төрхийг уран сайхны аргаар сэргээн дүрсэлжээ. Зохиолд олон түүхт хүмүүсийн зэрэгцээгээр мөн цөөнгүй уран сайхны дүр бүтээсэн байна. Инжинашийн амьдарч байсан цаг үед Манж Чин гүрний эрх баригчид монгол оронд хятадын тариачин, худалдаачдыг үй олноор оруулан газар нутгийг нь тариалангийн талбай болгох, хүн амыг нь хятадчилан устгах хорт бодлого нэгэнт эхэлсэн байв. Чухам тиймээс зохиолч маань “Товчит тольт”-доо энэ бодлогын хорыг уудлан илчилж, улмаар романыхаа хэсэгт монголчууд тусгаар тогтнолынхоо төлөө үнэнч тэмцэж ирснийг бичсэнээрээ монголчуудын үндэсний бахархлыг сэргээн, эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөө 300 шахам хошууны монголчууд цаазаа чангалж, цэргээ шалган боловсруулж, хүчээ нэгтгэн тэмцэхийг уриалан дууджээ. Энэ бол зохиолын амин гол санаа юм.

Хөх судрын судалгаа нь 1950-иад оноос хэлсэн боловч түүнийг хэл шинжлэл, уран зохиолын талаас нь авч үзсэн болохоос бус түүх, түүний дотор цэргийн урлагийн түүхийн талаас авч үзсэн удаа үгүй юм.

Тус зохиолд цэргийн хэрэг, түүний онцлог, мөн чанарыг "Аливаа цэргийн ёс нэгэн хүн эндүүрэн хөдөлвөөс хэдийчинээ түмэн хүний амь бусниж, хөнгөн болвоос цэрэг дарагдаж, хүнд болвоос улс мөхөх их хэрэг холбогдсон тул цэргийн цаазыг улсын цаазаас хатуу тогтоожээ" хэмээн оновчтой, жинтэй тодорхойлсон байна.

Ерөөс цэргийн шинжлэх ухааны зорилт нь цөөнөөр олныг ялах арга сүвийг олоход оршдог. Энэ бодлого үе үеийн монгол жанждын оюун сэтгэлгээний эхлэл байсаар ирснийг түүх гэрчилдэг бөгөөд энэ зохиолын эзэн ч **"Ямарваа цэрэг хурц чийрэг, уран оновчтой дор байх буйяа. Олон арван дор үгүй"** (1167) хэмээн өнөөгийн бидний ярьж, хүсч буй цомхон чадварлаг зэвсэгт хүчинтэй байхын чухлыг заажээ.

"Цэргийг хэрэглэх ёс нь салхин гал мэт түргэн болвоос зохино" (227) хэмээн цаг хугацааны хүчин зүйл, тасралтгүй эрчимтэй давшихын ач холбогдлыг тодорхойлсон байна.

"Сүүг самарч буцлахыг зогсоохоос тогооны ёроолын галыг унтраа" (260) хэмээн дайсны эмзэг буюу амин газар нь гол цохилт өгөх хэрэгтэйг заасан бол "Бэрх хэдрийг эзлэх нь батлан сахихуйяа хэрэгтэй, эсэргүүцэн байлдахуйд тусгүй" (319) хэмээн бартаа ихтэй газар орон хориглоход ашигтай, давшихад ашиггүйг тэмдэглэжээ.

Цэрэг дайны түүхийн туршид хоёр тал хүн хүчнийхээ тоог цуцалсаар ирсэн билээ. Цэргийнхээ тоог хэт олон хэмээн сүрдүүлэх, цуурхал тараах явдал мөн аль ч үед түгээмэл байжээ. Гэтэл Ванчинбал "Цэрэг цөөхөн бөгөөд (атал Х.Ш) тоо олон (хэмээн зарлаваас Х.Ш) болвоос сүр харин буурна. Цэрэг олон бөгөөд тоо цөөн болвоос (гэж зарлаваас) сүр сая бадарна" гэж цэргээ олон байх тусам дайсандаа цөөн гэж үнэмшүүлэн эсрэг тал нь хүчээ хэтрүүлэн үнэлж байх ашигтайг сургасан байна. Энэ санааг улам тодруулж "Цэрэг хэрэглэхүй дор үнэн гэтэл худал, худал гэтэл үнэн, дайсан этгээдэд ухаанаа эс баригдваас энэ даруй тэргүүн" (761) нэгэн зорилт мөн хэмээн цэргийн ов мэх бол монгол цэргийн байлдах арга ухааны амин сүнс мөнийг удаа дараа цохон тэмдэглэсэн байна. Энэ мэт цэргийн хэргийн онол, үндсэн зарчим, "алтан" дүрмийн шинжтэй, өнөө хүртэл үнэ цэнээ алдаагүй, хойшид алдахгүй сургаал номлолоор тус зохиол дүүрэн юм.

Эртний монголчууд цэргийн хэргийн өндөр боловсролтой байсан нь мэдээж юм. Түүнгүйгээг дэлхийн талыг эзэлж чадахгүй

5. Мухулай өөрөө 5 барсын жанжинаа авч морины толгой болов. "Аянгын сум" нэр өгөв.

6. 1,8 түм цэргээр морины дэл

7. Хонгорайдын Ачинай сэцнээр морины мант хийв.

8. Оюунцэцэн, Оюунгоо, Үнэн төр, Төгсцогт 4-д тус бүр 1,4 түм цэрэг өгч жолоо, цулбуур, 2 дөрөө хийж

9. Үлүхү сайдаар эмээл.

10. Баян хиагаар ташуур

11. Хударга баатарт Аргусаны Хорголжийг хавсарган, Чингисийн 4 авч морины хойд ууц сүүл болгож,

12. Чингис морийг унах эзэн болж "Ажнай морины" хазаарын төмөр, ишт цаазны зэвийг Мухулай өөрөө барьж сар илүү сургуулилав." (Энэ зохион байгуулалт нь одоогийн хиймөрийн дарцаг болсон юм гэнэ) хэмээн тэмдэглэсэн байх бөгөөд Найманыг дайлахын өмнө энэ хүлгийн жагсаалын 9 нэгжийг 9 өнгийн туг ба өнгийн хуяг дуулгатай болгожээ. (978)

Найманыг дайлахын өмнө 9 өнгө туг, хуяг дуулгатай 9 анги цэрэг байгуулж эхний буу тавихад тэдгээр нь 4 хүчтэн хөлт ажнай хүлгийн жагсаал болгов. (Энэ 9-ийг 9 эн цэрэг гэжээ)

2-р буу тавьж 9 эн цэрэг хоёронт эргэмэгц 32 араа шүдтэй "Арслангийн амны" жагсаал болно.

3-р буу тавихад 9 эн цэрэг гурвантаа мушгирмагц "Дөрвөн соёот хурц барсын шүдний" жагсаал болно.

4-р буу тавихад 4 салж "Дөрвөн хувилгаан хөлт луугийн хумсны" жагсаал болно

5-р буу тавихад Цэрэг тавантаа ангижирмагц "Хоёр төмрийн жигүүрт гарьдын хошуу"-ны жагсаал болно.

6-р буу тавихад 9 эн цэрэг 9 салж "Луу"-гийн жагсаал болно. (Энэ луу дотроо 9 янзын хүчтэй 9 хувилбар гаргана.) Үүнд:

1. Сүрт луу, 2. Хамгаалагч луу, 3. Дарангуй луу, 4. Хядагч луу, 5. Дуурсагч луу, 6. Гийгүүлэгч луу, 7. Амсагч луу, 8. Бэхлэгч луу, 9. Элдэвлэгч луу болно.

7-р буу тавихад 9 лууны 4 мөч, толгой, сүүл, 45 анги жагсаал болно.

8-р буу тавихад 36 мөчний 180 хумсны дэлгэж гарах жагсаал болно.

9-р буу тавихад 9 эн цэрэг гэнэт нийлж, "Аянгын сумны хурц түргэн галын" жагсаал болно.

10-р буу тавихад 9 эн бас урваж дөрвөн хүчтэний хөлт "Ажнай морины" жагсаал болно. (978. 181-983)

Эдгээр баримтаас үзвэл цэргээ олон ангид хуваан бүлэглэж томоохон бүлэг бүрт араатан амьтны нэр оноосон байх бөгөөд байлдааны журмыг янз бүрээр хувиргахад түүний шинж чанар, цохилтын хүчний далайц өөрчлөгдөж, тийнхүү өөрчлөгдсөн байлдааны журам бүрт мөн араатан амьтны нэр оноосон байна. Энэ нь өнөөгийн их бууны галын төрлүүдийг араатан амьтны нэрээр нэрлэдгийг эрхгүй санагдуулж байгаагаараа сонирхол татах бөгөөд дэлхийн цэргийн урлагийн практикт бодитой байсан зүйл уламжилж ирснийг гэрчилнэ.

Цэргийг нэгэн цул бөөнөөр бус тус тусдаа бие даан байлдах олон тусгай анги болгон зохион байгуулдаг уламжлал монгол цэрэг байжээ. Энэ нь цэргийн байлдах чадавхи, хөнөөх чадварыг асар ихээр нэмэгдүүлдэг гэх сэтгэгдлийг эл зохиол төрүүлдэг.

Зохиолын 1654 дүгээр талд монгол цэргийн 18 жанжинд тус бүр 1 түм цэрэг өгч 18 зам болгоод Нэгд: 3 жанжинаар эзнийг хамгаалах 3 гарьд болгож,

хоёрт:

1. Галзуу барсын жагсаал –1(Хаан, Боорчи, Буурал)
2. Гал лууны жагсаал –1 (Зэв, Зэлмэ)
3. Бор арслангийн жагсаал –1 (Зэв, Зэлмэ)
4. Хошуут гарьдын жагсаал –1 (Зэлмэ)
5. Ажнай морины бага жагсаал –1(Мухулай) хэмээн 18 зам цэргээ 5 жагсаалд хуваагаад зарлиг болсон нь:

"Боорчи, Буурал хоёр 3 өдөр тэдгээрийн (дайсны) цэрэгт үхээнц буурай дүр үзүүлээд 20 газар ухарч хүрээ буу. Тэд давшин ирвээс манай аргад орсон болой. Эс хөөвөөс энэ аргаар болохгүй" гэж үзээд 5 анги цэрэг ухарсаар байгаад гэнэт 5 анги салан дайран орвол дайсан хот руугаа зугтахад нь Бууралын цэрэг тэдэнтэй хамт хотод нь орж уг хотыг (хотоос гарган байлдах сонгодог арга энэ юм) авсан жишээ байна.

Монголын морьт цэргийн маневрлах өргөн бололцоонд түшиглэн ийнхүү бие даан үүрэг гүйцэтгэх олон анги зохион байгуулж, тэр нь өндөр үр дүнд хүрч байжээ.

Гуравдугаар зүйл.

"Цэрэг болвоос тэргүүн дор аргыг эрхэмлэнэ. Хэрвээ омогт дайснаа үхээнцийг үзүүлж түүний омгийг төрүүлэн сэрэмжгүй болгож гэнэдүүлэн дармой. Хэрвээ аймхай дайснаа учирваас хуурмаг сүрээр түүний сөсийг хэмхрүүлэн айлгаж тулгамой" (1021) хэмээн зохиогч бичсэн байна. Тус зохиолын Алтан улсыг дайлах хүртэл буюу эхний

2 бодит 40 гаруй удаагийн байлдаан тэмдэглэгдсэнээс тал хувийг нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг.

Тэдгээрт монгол цэргийн байлдааны үндсэн 3 төрөл (дайрах, буруулах, хороолох) бүрийн баялаг арга хувилбаруудыг цөм бүрэн, тод томруун харуулжээ. Янз бүрийн барилаар давших ба буруулах, татан байлдах, эргэж нүүр дээр нь асгах, мөрдөн хөөх, өдөөн дагуулж бүгээнд авчрах буюу хотоос нь гаргах, нуман түлхүүрийн барилаар хад хясаа буюу ус мөрөнд шахах, дэрлэх ба тойрох маневр үйлдэх, галдах, задлах зэрэг эртний түүхэн сурвалжуудад тэмдэглэгдсэн бүхий л өвөрмөц аргуудыг удаа дараа хэрэглэсэн жишээ олон байна.

Эртний түүхийн сурвалжид ер үзэгдээгүй сонин сонин арга хэрэглэсэн жишээ ч цөөнгүй.

Зохиолын 761-763 дугаар талд "Тугмаг улсыг эзлэх байлдааны бодлого бичээстэй байна. Тугмал улс хүчирхэг цэрэгтэй тул түүнийг аргаар эзлэх шийдвэр гаргажээ."

Цэрэг мордохын өмнө арван тав, зургаан насны шинэ залуу дайчдыг туршлагатай багш жанждад хуваарилан өгч, тэднийг сургах даалгавар өгөв. Тугмагтай хиллэн орших, нэгэнт өмнө нь эзэлсэн бэлчээр ус сайтай Сарлаг уулсыг Тугмагийг эзлэх хэрэгт түшиц болгон ашиглахаар шийдэв.

Боорчийг мордуулж Сарлагаас хэд хэдэн баг цэрэг элсүүлэн, түүнийгээ арван түм хэмээн цуурхал тарааж Тугмагийн зүг довтлоод эргэв. Энэ үед монголын цэрэг Тугмагийн баруун хилд гарчээ.

Зүүнээс нь довтлох дүр үзүүлэхэд Тугмагийн цэрэг зүүн хилдээ давхин гарна. Энэ үед баруунаас нь довтлох дүр үзүүлэхэд баруун хил рүүгээ давхин гарна. Ийнхүү хоёр талаас нь ээлжлэн довтолж энэ завсар цэргээ боловсруулж агтаа таргалуулан хавар зуныг өнгөрөөжээ. Харин Тугмагийн цэрэг, морь нутгийнхаа хоёр хилийн хооронд шидэгдсээр туйлдан доройтсоны дээр тэдний хуурамч ажиллагаанд дасч сонор сэрэмж нь доройтжээ.

Гэтэл намрын нэг өдөр Чингисийн цэргийн шинэ хүч хойд талаас нь гэнэт дайрч, нөгөө хоёр талын цэрэг ч араар нь зэрэг цөмрөн орж Тугмагийг эзлэв. Ийм аргаар үнэний дотор худлыг агуулах хэмээн томьёолжээ.

Зохиолын 1643 дугаар талд орших бас нэг жишээг сонирхоё. "Зан жоу хилэн ихтэй тул (найруулан авав) уурлуулан хотоос гаргаж, бид Сүн шан уул дотор цэрэг бүгүүлж түүнийг дагуулан оруулж алсугай. Би урьдаар байлдъя. Чи 20 газрын ард нарсан шугуйд бүгж хүлээ. Би хуурамчаар буруулан тэнд хүрэхэд чи тосон гарч байлд.

Би зугтан гарч бас 20 газрын хойно хулсанд бүгээд чамайг тэнд хүлээ. Намайг тосон байлдахад чи зугтан гарч Хэй шан уулын хавцал хүрч уулын 2 энгэрийг дагуулан хулхавч нумтай цэрэг бүгүүлж хүлээ. Би тэдэнтэй нэлээд байлдмагц уул руу зугтахад тэд лав хөөн одмой. Түүний цэрэг уулын хавцлын амаар ормогц чи хоёр этгээдээс хавцлын амыг мод, чулуугаар бөглөтөл, би эргэж байлдана” хэмээн Алтан улсын нэгэн хотыг авах төлөвлөгөө хийж тэр ёсоор байлдан ялж байв.

Энэ бол өнөөгийн цэргийн онол практикт зориуд санаатайгаар ухралт зохион байгуулахын сонгодог жишээ юм.

Цэргийн тактик нь эзэмшиж буй зэвсгийн хүч чадал, шинж чанартай амин холбоотой байдаг. чухамхүү хүч, зэвсэг хоёрын хөнөөлийн чадварыг бүрэн дүүрэн ашиглахын төлөө тэмцэл л цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж ирсэн билээ. Эртний монгол цэрэг ч зэвсгээ ашиглах, хүн ба зэвсгийн хүчийг уялдуулан зохион байгуулах өөрийн “шинжлэх ухаан”-тай байжээ. Үүнийг зохиолын III бүлэгт буй дараахь жишээ нотолно. Тэнд бичсэн нь: Жонон:

“Богино ардад дэгээ бамбай бариулж, татанги ардад холговч нум бариулж, чийрэг ардад туг хиур бариулж, баатар ардад хэнгэрэг бариулж”

1. Бууралыг дуудаж: “Чи 1 мянган цэрэг авч Хэрлэн мөрнийг шөнөөр гаталж цаад хөвөөнд бүгтүгэй. Маргааш бичин цагийн сүүлд тайчууд хэрэв дарагдаж, мөрний хагасыг гэтэлсэн үед цэргээ авч хөндлөн этгээдээс тосон байлдаж тэдний морь хуягийг булаагтун. Энэ маш чухал хэрэг.

2. Чулуун, Зэв хоёулыг дуудаж: “Та хоёр 2000 цэрэг авч, шөнөөр мөрнийг гаталж, эндээс 30 газрын үзүүрт буй Тарвагын Манханы хоёр этгээдэд бүгтүгэй. Маргааш наран шингэх үед 3 аймгийн цэрэг хэрэв дарагдваас, лавтай тэр зүг шургахаар зугтана. Их дарагдваас, түүнд шургалгүйгээр өнгөрөн гарна. Түүнийг та бүү тос. Бас бүү сундал. Дунд хагасыг өнгөрүүлээд, гэнэт гарч, тасдан алж, байлдан эргэ” хэмээн яв цав үүрэг тавьж харилцан ажиллагааг **байр, цаг, үүргээр** зохион байгуулж байна. Дайсан байлдахыг хүсч шаардан ахуйд Мухулай ухарч, цэргээ хооллон цатгасны дараа байлдаанд оруулан төлөвлөгөө ёсоор ажиллан ялж байна.

Өнөөдөр ч бид байлдааны үүрэг тавьж, төрөл мэргэжлийн цэргийн харилцан ажиллагааг зохион байгуулахдаа үүнээс өөрөөр байж чаддаггүй. Дээр өгүүлсэн жишээ нь эртний монгол цэргийн жанжин сэхээтнүүд цэргийн хэргийн онол практикт үнэхээр төгс боловсорсон байсны тод гэрч мөн.

Дүгнэлт.

1. Энэ зохиолд байгаа цэргийн хэргийн онол, практиктай холбоотой бүх үг хэл, үйл хэрэг гагцхүү Мухулайгаас гарч байна. Энэ нь өдгөө бидэнд олдоогүй авч Мухулайн бичсэн цэргийн судар Инжинашийн гарт байсан юм биш байгаадаа гэх сэжиг таавар төрүүлнэ.

2. Зохиолч цус яс нэгтнүүдээ Манжийн дарлалын эсрэг тэмцэлд зөвхөн уриалан дуудаад зогсоогүй, тэмцлийн арга нь цэргийн байх учраас зэвсэгт тэмцлийн арга тактикийг заан сургах зорилтыг тус бүтээлдээ тавьжээ. Тиймээс ч тэрбээр ялахуйн ухааны онол, байлдааны төрөл арга, барилуудыг боловсруулан эл номоороо сурталчилжээ. "Дайсны ийм арга та нарт олон тааралдана шүү. Сайн санаж яв" хэмээн тэрбээр нэг бус удаа цохон тэмдэглэсэн байдаг нь энэ зорилтын нь илрэл юм. Гагцхүү цэргийн эрдэмд нийт монголчуудыг сургаж буйгаа далдлах, нөгөө талаар нийтэд сонихролтой байж тэр ч чанараараа хорхойтон суралцахад дөхөм болгох үүднээс уг түүхэнд уран зохиолын хачир оруулан бичжээ.

3. Энэ утгаар болон угаас зохиомжийн талаас нь ч аваад үзсэн "Хөх судар"—ыг түүхэн роман гэхээс түүхэн нийтлэлийн нэг хэлбэр—түүхэн найруулал гэж үзэх нь үлэмж зохистой.

4. "Хөх судар" нь эртний монгол цэргийн урлагийн түүхийн үнэт сурвалж, сурах бичиг мөн бөгөөд өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй. Гагцхүү уран зохиолын халхавч, дээвэр туурганаас нь түүхийн яс модыг ялган салгаж авч үзэх хэрэгтэй. Үүний тулд маш их судалгаа хийх шаардлагатай.

5. Аман соёл ноёлсон нүүдэлч монголчуудын түүх бичлэгийн уламжлал өнөө алдагджээ. Ой тойнд үлдэцтэй хурц шүлэг, яруу дүрслэл түүх бичлэгээс маань арилж, хуурай онол, албаны модон хэл давшлан эзэлснээс үүдэн ард түмэн, түүний дотор бага дунд сургуулийн сурагчид түүхээс зэнзийлэн зайлсхийх болжээ.

Иймд цэвэр шинжлэх ухааны бус нийтийн сурталчилгааны бүтээл бага, дунд сургуулийн түүхийн сурах бичгүүд нь "Монголын нууц товчоо", "Хөх судар" шиг яруу тунгалаг хэл найруулгатай байх хэрэгтэй.

Дэд доктор Х. Шагдар